

ХИЧЭЭЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Хичээлийн нэр: Байгаль хамгаалал ба тусгай хамгаалалттай газар нутгийн менежмент
Nature conservation and special protected area management


Хичээлийн индекс: ENVI802
Хичээлийн ангилал: Доктор
Хичээлийн төрөл: Мэргэжлийн заавал судлах хичээл
Хичээлийн багц цаг: 3 ББц
лекц 2 Бц
семинар 1 Бц

Судлах улирал: Бүх улирал
Нийт хуудасны тоо: 6
Цахим хичээл: Бүрэн цахим хичээл
<https://studio.online.num.edu.mn/course/course-v1:NUM+ENVI802+2022>

Боловруулсан:

Бүрэлдэхүүн сургууль	Тэнхим	Багшийн нэр, цол, зэрэг	Гарын үсэг
ХШУИС	Хүрээлэн буй орчин, ойн инженерчлэлийн тэнхим	Н.Оюунчимэг, дэд профессор	

Зөвшөөрсөн:

Бүрэлдэхүүн сургууль/ тэнхимийн хөтөлбөрийн дэд хорооны нэр	Хэлэлцүүлж зөвшөөрсөн хурлын огноо	Хөтөлбөрийн дэд хорооны даргын нэр, цол, зэрэг	Гарын үсэг
ХБООИ-ийн тэнхимийн хөтөлбөрийн дэд хороо	2023-05-31	Хөтөлбөрийн дэд хорооны дарга, профессор Ч.Сономдагва	
ХШУИС-ийн хөтөлбөрийн дэд хороо	2023-05-31	Хөтөлбөрийн дэд хорооны дарга, дэд профессор Д.Бямбажав	

Баталсан:

Хичээлийн хөтөлбөрийг МУИС-ийн ХШУИС-ийн Хүрээлэн буй орчин, ойн инженерчлэлийн Хөтөлбөрийн дэд хорооны 2023 оны 05-р сарын 31-ны өдрийн хурлаар хэлэлцэж батлав.



Хичээл заах багш нарын мэдээлэл:

Тэнхимийн нэр: Хүрээлэн буй орчин, ойн инженерчлэлийн тэнхим
Багшийн нэр, цол зэрэг: Н.Оюунчимэг, дэд профессор
Утас: 88000749
Цахим шуудан: oyunchimeg@seas.num.edu.mn
Өрөө: 3-р байрны 313
Зөвлөгөө өгөх гараг, цаг: Өдөр бүр 09:00 – 18:00
Цахим хуудас: <http://seas.num.edu.mn/dep/defe/aboutus/teachers/128/detail/>

Тэнхимийн нэр:
Багшийн нэр, цол зэрэг:
Утас:
Цахим шуудан:
Өрөө:
Зөвлөгөө өгөх гараг, цаг:
Цахим хуудас:

Энэ хичээлийн тодорхойлолтыг 2020 онд батлагдсан “МУИС-ийн цахим сургалтын түр журам”-ыг баримтлан боловсруулав.

ХИЧЭЭЛИЙН ЗАЛГАМЖ ХОЛБОО

Өмнө үзсэн байх хичээлийн нэр, индекс:

- | | |
|---|---------|
| 1. Хүрээлэн буй орчин судлал | ENVI200 |
| 2. Тогтвортой хөгжил ба ногоон хөгжлийн бодлого | ENVI312 |

Зэрэгцүүлэн үзэхэд тохиромжтой хичээлийн нэр, индекс:

- | | |
|--------------------------------------|---------|
| 3. Ногоон хөгжлийн бодлого, стратеги | ENVI618 |
|--------------------------------------|---------|

ХИЧЭЭЛИЙН ЗОРИЛГО, АЧ ХОЛБОГДОЛ

Энэ хичээл нь байгаль орчны хамгаалах уламжлалт болон орчин үеийн арга хэрэгсэл, хүний үйл ажиллагааны улмаас байгаль орчинд тулгамдаж буй асуудлууд, байгаль хамгаалах/нөхөн сэргээх талаар хүн төрөлхтний авч буй арга хэмжээ, үүнд шинжлэх ухаан, улс төр, бизнес, хүмүүсийн гүйцэтгэх үүрэг, тогтвортой хөгжлийн асуудлын талаар оюутнуудад өргөн хүрээний ойлголт мэдлэг олгож, дэлхий нийтийг хамарсан уур амьсгалын өөрчлөлт гэх мэт хүн төрөлхтний өмнө тулгараад буй байгаль орчны асуудлуудыг экологийн шинжлэх ухааны суурь ойлголт болон байгаль хамгааллын үүднээс авч судлахаараа ач холбогдолтой.

ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА

Байгаль хамгаалал хичээл нь байгаль орчин болон экологийн шинжлэх ухааны ерөнхий мэдлэг дээр тулгуурлан байгаль орчныг хамгаалах уламжлалт болон орчин үеийн арга хэрэгсэл, тэдгээрийн ашиглалт, байгаль хамгааллын төлөвлөлт болон удирдлагын үндсэн ойлголт, тогтвортой хөгжлийн үндсэн зарчмууд, тусгай хамгаалалттай газар нутгийн менежмент, байгалийн нөөцийн ашиглалт болон хамгаалалт, уур амьсгалын өөрчлөлт, хүрээлэн буй орчны бохирдлын асуудлууд, газар ашиглалт, нөхөн сэргээлтийн талаар заах онол, семинарын хичээл юм. Мөн байгаль хамгаалах практикт ашигладаг төрөл бүрийн арга хэрэгсэл, нээлттэй стандарт, тусгай хамгаалалттай газар нутгийн төлөвлөлт, менежмент, дасан зохицох менежмент зэрэг сэдвийг хамарна.

Based on the general knowledge of environmental and ecological sciences, this course covers the following concepts: traditional and modern methods of environmental protection and their use, basic concepts of conservation planning and management, basic principles of sustainable development, management of specially protected areas, use of natural resources, climate change, environmental pollution issues, land use and rehabilitation. It also covers topics such as various tools used in conservation practice, open standards, planning and management of protected areas, and adaptive management.

ХИЧЭЭЛЭЭР ЭЗЭМШИХ МЭДЛЭГ, ЧАДВАР, ДАДАЛ

Тус хичээлийг судалснаар байгаль хамгааллын үндсэн онол, арга хэрэгслийн талаар суурь мэдлэгийг эзэмшихийн зэрэгцээ байгаль орчинд учирч буй аюул дарамтыг үнэлэх, байгаль хамгааллын төлөвлөлтийн аргазүй, программ хангамжийг ашиглах чадвар, дадлыг олж авна. Онолын мэдлэгийн хувьд хичээлийн агуулга хэсэгт бичсэн мэдлэгүүдийг үндсэн сурах бичигт суурилан олж авна. Байгаль хамгаалал хичээлийг судалснаар оюутнууд дараах чадварт суралцсан байна. Үүнд:

- ~ Байгаль хамгаалах өнөөгийн практик болон үндсэн онолын үзэл баримтлалд шүүмжлэлтэй хандах
- ~ Байгаль хамгаалах практик, байгаль орчны менежментэд хүн, зах зээл, шинжлэх ухааны байр суурь, үндэслэлд дүн шинжилгээ хийх
- ~ Онолын мэдлэг, байгаль хамгаалал, төлөвлөлтийн арга хэрэгслийг практикт ашиглах
- ~ MIRADI программ ашиглан тусгай хамгаалалттай газрын төлөвлөлтийн аргазүйн дагуу менежментийн төлөвлөгөө боловсруулах
- ~ Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн үр ашигт байдлыг МЕТТ аргаар үнэлэх

ЗААХ АРГА БАРИЛ

Сургах болон сурах үйл явц нь шавь төвт сургалтын арга барилд тулгуурлах ба лекц, харилцан яриа, семинар, бие даалт, тайлан бичилт, судалгаа гүйцэтгэх, мэдээ цуглуулах, түүнд анализ хийх, илтгэл тавих гэх мэт олон хэлбэрээр явагдана.

ХИЧЭЭЛИЙН ДААЛГАВАР

Лекцийн хичээлээр олж авсан ойлголтыг нь бататгах зорилгоор лекц бүрийн төгсгөлд тухайн сэдвийн ойлголтыг бататгах түлхүүр асуултуудыг суралцагсдаас асуух болно. Семинарын хичээлийн даалгаврыг суралцагсад бие даан гүйцэтгэж, байгаль хамгаалал болон байгаль хамгааллын төлөвлөлтийн арга, хэрэгслийг ашиглаж сурна.

ХИЧЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ (ирц, явц, шалгалт)

Суралцагчдын мэдлэг, ур чадварыг дараах хэлбэрээр үнэлнэ. Үүнд:

1. Ирц, хичээлийн идэвх
2. Явцын шалгалт
3. Даалгавар, бие даалт
4. Улирлын шалгалт

Дүгнэх зүйл	Оноо	Тайлбар
Ирц, идэвх	10	Цахим хичээлд хандалтаар үнэлнэ.
Явцын шалгалт	15	Эхний найман сэдэв
Улирлын шалгалт	20	Бүх үзсэн сэдэв
Даалгавар, бие даалт	55	Гэрийн даалгаврын гүйцэтгэл, байгаль хамгаалал болон төлөвлөлтийн арга хэрэгслийг ашигласан байдал.
Нийт	100	

ХИЧЭЭЛД АШИГЛАХ НОМ, СУРАХ БИЧГИЙН ЖАГСААЛТ

Үндсэн сурах бичиг:

1. Daniel. D and et al, (2014) “Natural Resource Conservation: Management for a Sustainable Future,” 10th edition, Pearson New International, USA, pages 663, ISBN 13: 978-1-292-04098-1, in Mongolian
2. В.И.Титова ба Е.В.Дабахова, (2003) “Охрана окружающей среды”, Учебное пособие, Издательство Волго-Вятской академий государственной службы, Нижний Новгород, ISBN: 5-85152-344-1, хуудас 213, ISBN 5-85152-344-1, Орос хэл.

Нэмэлтээр унших ном:

1. Х.Мөнхбаяр ба М.Мөнхбаатар, (2006) “Хялбаршуулсан экологи”, Адмон пресс, - 154 хуудас, ISBN:9789992907657 0.00, Монгол хэл.
2. БОАЖЯ, (2019) “Монгол орны байгаль орчны төлөв байдал 2017-2018”, редакторууд А.Энхбат, П.Цогтсайхан ба Г.Нямдаваа, Улаанбаатар хот, хуудас 186, Монгол хэл

СУРГАЛТАД АШИГЛАХ МАТЕРИАЛ:

1. MIRADI программ
2. METT-Management effectiveness tracking tool

ХИЧЭЭЛИЙН СЭДЭВЧИЛСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

Лекцийн хичээл:

7 хоног	Хичээлийн сэдэв	Сэдвийн агуулга	Цаг
1	Байгаль хамгааллын тухай үндсэн ухагдахуун, орчин үеийн хандлага. Хүн-байгалийн харилцаа ба экологийн хямрал	Байгалийн орчин, байгаль хамгааллын уламжлалт болон орчин үеийн хандлага. Байгалийн болон хүн төрөлхтний үүсгэсэн орчны талаарх судалгаа, ангилал. Хүн-байгалийн харилцааны түүхэн онцлог. Хүний нөлөөгөөр үүссэн экологийн томоохон хямралууд	2
2	Биосфер нь хүний амьдрах орчин болох нь.	Биосферийн бүтэц, бүрэлдэхүүн, хил хязгаар. Биосфер дэх экосистемийн төрлүүд, түүний үйлчилгээ. Биосферийн үндсэн хуулиуд. “Хүн-байгаль” хэмээх системийн хуулиуд.	2
3	Байгалийн нөөц баялаг ба байгалийн ашиглалт	Байгаль хамгааллын үндсэн зарчмууд. Байгалийн нөөц, түүний төрөл, байгаль ашиглалтын хэлбэрүүд.	2
4	Байгаль хамгааллын үндсэн арга хэрэгсэл	Байгаль хамгааллын хууль эрхзүй, эдийн засгийн болон технологийн арга хэрэгсэл, хөшүүрэг	2
5	Аж ахуйн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл. Агаарын чанар, хаягдал багатай технологи	Аж ахуйн үйл ажиллагаа, тэдгээрээс байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн төрлүүд, байгаль орчны бохирдол. Агаар мандлын үндсэн бохирдуулагч, гадна болон дотоод агаарын бохирдлын үр дагавар, агаарын бохирдолтой тэмцэх арга зам	2
6	Эрдэс баялгийн ашиглалт ба БО-ны нөлөөлөл. Бохирдлыг багатай технологи	Түлш-эрчим хүч, аж үйлдвэрийн түүхий эдийн зохистой ашиглалт, хамгаалал. Зохистой уул уурхай.	2
7	Усны болон газрын нөөцийн ашиглалт, хамгаалал	Усны ашиглалт, усны нөөцийн бохирдол, усны зохистой ашиглалт ба хамгаалал. Хөрсний бохирдол, түүнд нөлөөлж буй хүчин зүйлс, газрын доройтол, бэлчээрийн талхагдал цөлжилт. Газрын зохистой ашиглалт, хамгаалал ба цөлжилтийг сааруулах арга зам	2
Явцын шалгалт		Дээрх сэдвүүдийг хамарна	
8	Биологийн нөөцийн хамгаалал ба Тусгай хамгаалалттай газар нутаг	Ургамлын нөөц, ойн нөөц, амьтны нөөцийн аж ахуйн болон амьжиргааны ач холбогдол, зохистой ашиглалт, хамгаалалт. ТХГН-ийн зорилго, ангилал, онцлог, байгаль хамгааллын ач холбогдол	2
9	Тусгай хамгаалалттай газар нутгийн менежмент-1: Төлөвлөлт	ТХГН-ийн менежментийн төлөвлөлт, аргачлал	2
10	Тусгай хамгаалалттай газар нутгийн менежмент-2: Үр ашигт байдал	ТХГН-ийн менежментийн үр ашигт байдлын үнэлгээ, аргазүй (ЕХ-ны арга хэрэгслүүд)	2
11	Хотжилт ба хотын дэд бүтэц: байгальд түшиглэсэн шийдэл. Хог хаягдлын менежмент	Хотжилт, дэд бүтцээс байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл. Хог хаягдлын бүтэц, ангилал, эх үүсвэрүүд. Хог хаягдлын менежментийн орчин үеийн чиг хандлага	2
12	Тогтвортой хөгжил ба байгаль хамгаалал. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох нь	Тогтвортой хөгжлийн байгаль орчны зорилтууд, үндсэн зарчмууд. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох арга замууд Хичээлээр үзсэн сэдвүүдийг сэргээн ярилцаж, нэгтгэн дүгнэх	2
Улирлын шалгалт		Улирлын турш үзсэн сэдвүүдийг хамарна	
Нийт			32

Семинарын хичээл:

7 хоног	Хичээлийн сэдэв	Сэдвийн агуулга	Цаг
1	Монголчуудын байгаль хамгааллын уламжлал. Хүний үүсгэсэн орчин. Хүний хэрэгцээ, түүний төрлүүд	Монголчуудын байгаль хамгаалах арга ухаан, байгаль орчны ёс зүй, онцлог. Өөр 2 улстай харьцуулсан дүгнэлт хийх. Орчны талаарх эрдэмтдийн судалгаатай танилцаж ялгааг таних. Хэрэгцээнээс хэрэглээ үүсэх нь. Өөрийн экологийн ул мөрийг тооцож, хэрэглээндээ дүгнэлт хийх	2
2	Экосистемийн үйлчилгээ	Экосистемийг ангилал, тэдгээрийн үйлчилгээг тодорхойлох	2
3	Монгол улсын байгалийн нөөц ашиглалтын өнөөгийн нөхцөл, цаашдын чиг хандлага.	Монгол орны эрдэс баялгийн нөөц ашиглалтын өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага.	2
4	Байгаль хамгааллын үндсэн арга хэрэгсэл, хөшүүргүүд	Байгаль орчны салбарын хууль эрхзүйн орчин, олон улсын гэрээ конвенц	2
5	Хүний үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл. Байгалийн нөөцийн менежмент	Монгол улсын эдийн засгийн тэргүүлэх салбарууд, тэдгээрээс байгаль орчинд үзүүлж буй нөлөөлөл. Байгалийн нөөцийн менежментийн талаар үзэл баримтлал	2
6	Эрдэс баялгийн ашиглалт, хамгаалалт	Баялгийн хараал. Зохисгүй уул уурхайн сөрөг нөлөөлөл. Монгол улс дахь уул уурхайн үйлдвэрлэл - хэлэлцүүлэг	2
7	Усны нөөцийн ашиглалтын менежмент	Ус голлон хэрэглэгчид, тэдгээрийн хэрэглээний онцлог. Монгол улсын усны нөөцийн хэрэглээний зохицуулалт, усны менежмент.	2
8	Биологийн болон ойн нөөцийн ашиглалт, хамгаалалт. Тусгай хамгаалалттай газар нутаг нь байгаль хамгааллын үр нөлөөтэй арга болох нь	Монгол орны ойн нөөцөд тулгарч буй асуудал. Амьтан, ургамлын ховордлын зэрэг, Улаан номд орсон ургамал, амьтад. ТХГ-ын талаарх үндсэн ойлголт. Монгол улсын ТХГН-ийн сүлжээ, хөгжлийн чиг хандлага	2
9	Тусгай хамгаалалттай газар нутгийн менежмент: Төлөвлөлт-1	ТХГН-ийн менежментийн төлөвлөгөө боловсруулах аргазүй, МИРАДИ программын хэрэглээ	2
10	Тусгай хамгаалалттай газар нутгийн менежмент: Төлөвлөлт-2	ТХГН-ийн менежментийн төлөвлөгөө боловсруулах дадлага ажил	2
11	Хотжилт, дэд бүтэц. Хог хаягдлын менежмент	Улаанбаатар хотын хот төлөвлөлт, тулгамдаж буй асуудал-шийдэл. Хог хаягдлын менежмент	2
12	Тогтвортой хөгжил ба байгаль хамгаалал. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох нь	МУ-ын төрийн бодлогын баримт бичгүүдэд НҮБ-ын ТХЗ тусгалаа олсон байдал. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох арга замуудыг тодорхойлох	2
Нийт			32